



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#2 (23)

Сар тутмын хэвлэл

<http://www.mnier.mn>

II сар

Сургалтын
хөтөлбөр ба
цахим контент

Боловсролын
үнэлгээ ба
цахимжуулалт

Боловсролын
салбарын хүний
нөөц ба цахим
технологи

Сургалтын орчин,
хэрэглэгдэхүүн
цахимжуулалт

Боловсролын
удирдлага, зохион
байгуулалт ба
түншлэл

"МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ХУВИРГАН ӨӨРЧЛӨЛТ-2024" ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН

Шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй хөгжил, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд гарч буй гэнэтийн өөрчлөлт, урьдчилан таамаглах боломжгүйгээр хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй төлөв байдлын улмаас дэлхийн улс, орнууд сургуулийн өмнөхөөс эхлээд бүх шатны боловсрол цаашлаад насан туршийн боловсролын хүрээнд 21 дүгээр зууны шинэ чадамжийн хөгжилд анхаарал хандуулж байна.

"Монголын боловсролын хувирган өөрчлөлт 2024" үндэсний чуулганы хүрээнд

- Сургалтын хөтөлбөр
- Боловсролын удирдлага, зохион байгуулалт
- Боловсролын үнэлгээ, мониторинг
- Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн
- Хүний нөөц хэрхэн хувьсан өөрчлөгдөж байгааг хэлэлцэж байна.



Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал, 21 дүгээр зууны хувьсал, технологийн хурдтай өөрчлөлт бид бэлэн үү? Сургууль, багш энэ өөрчлөлтөд бэлэн үү? Энэ өөрчлөлтөд дасан зохицсон Монгол хүнийг хөгжүүлэхэд боловсролд бид юуг хувиргах хэрэгтэй вэ? Эдгээр асуултын хариулт боловсролын хувирган өөрчлөлтийн суурь юм.

7 ЕБС-ийн хэвлэмэл сурах бичгийг цахим, интерактив хэлбэрт шилжүүлж байна.

8 Бага боловсролын математикийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор Финландын Туркугийн Их Сургуультай хамтран "Eduten" платформыг туршин, үндэсний хэмжээнд үе шаттайгаар нэвтрүүлж байна.


9 Мэргэжлийн болон дээд боловсролын салбарт үр дүн, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна.

10 Дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, чанарын баталгаажуулалтын эрх зүйн орчин шинэчлэгдэж, магадлан итгэмжлэх үйл явцад цахим технологийг нэвтрүүлж байна.

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ДЭЭД БОЛОВСРОЛ, НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙ



МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ХӨТӨЛБӨР



ГАДААДЫН БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ БАЙГУУЛЛАГААР



ЦААШИД ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА.




- 1 Дэлхийн болон үндэсний өв соёл, үнэт зүйлийг өвлөн уламжилдаг, эх дэлхийгээ хайрлан хамгаалдаг, хариуцлагатай, ёс суртахуунтай, эрүүл, насан туршдаа суралцах чадвартай иргэнийг боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөрөөр залгамж холбоотой, уялдаатайгаар бэлдэх;
- 2 Бүх түвшний сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулахад чиглэсэн үндэсний хэмжээний суурь судалгааг тасралтгүй хийж, судалгаанд суурилсан нэгдсэн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх;
- 3 Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт улс үндэстний болон дэлхий ертөнцийн өнөөгийн болон ирээдүйн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн, сурагчийн амьдрал, хөгжилд ач холбогдолтой, шаардлагатай чадамжийг хөгжүүлэхэд хөтөлсөн тогтвортой ба хувьсах агуулгыг тэнцвэртэйгээр тусгах;
- 4 Бүх шатны сургалтын байгууллагын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх хөтөлбөрийн чанарыг сайжруулж, хэрэгжилтийг хангах;
- 5 Бүх түвшний сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх үзэл санаа нь суралцагчийн ялгаатай хэрэгцээг харгалзаж, сонголт, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар суралцагчийн чанартай боловсрол эзэмших эрхийг хангахад чиглэх;
- 6 Боловсролын бүх түвшинд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих виртуал орчин, цахим номын сан, сургалтын нээлттэй материал, интерактив контент, платформыг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлан тасралтгүй хөгжүүлэх;
- 7 Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг цахим контент, сургалтын интерактив материалууд болон хэвлэмэл уламжлалт сургалтын нөөцтэй хослуулан дэмжих;
- 8 Бүх түвшний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд олон хэл, технологи ашиглаж шинэ мэдлэг хамтран бүтээх, мэдлэгээ хуваалцах, интерактив үйлээр суралцах, бодит асуудалд суурилсан, орчин үеийн идэвхтэй суралцахуйн онол, арга зүйг нэвтрүүлэх;
- 9 Бүх түвшний сургалтын байгууллага нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнд нь үндэслэн сургуулийн хөтөлбөрийн сайжруулалтыг тогтмол хийж, чанарын соёлыг төлөвшүүлэх;
- 10 Ерөнхий боловсролын ахлах ангийн сургалтын хөтөлбөрийг төрөлжсөн ахлах сургууль хэлбэрээр хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлж, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын сургалттай нягт уялдуулах;

БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭ БА ЦАХИМЖУУЛАЛТ САЛБАР ХУРАЛДААНД ОРОЛЦОГЧИД

“Монголын боловсролын хувирган өөрчлөлт-2024” үндэсний чуулганы Боловсролын үнэлгээ ба цахимжуулалт салбар хуралд аймаг нийслэлээс багш, боловсролын удирдах ажилтан, эцэг эх, суралцагчдын төлөөлөл болсон 110 оролцогч үнэлгээний талаар хэлэлцэв.


Хурлаар боловсролын хөгжилд үнэлгээний гүйцэтгэх үүрэг, манлайлал, үнэлгээний үр дүнд суурилсан багш, байгууллагын хөгжил, боловсролын үнэлгээний мэдээллийн сан, ашиглах боломжийн талаар ярилцан, үнэлгээг сайжруулах талаар санал бодлоо уралдуулав.




ҮНЭЛГЭЭ, ЦАХИМ ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР ОЛСОН АМЖИЛТ

- 1 Өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг олон улсын арга зүй, аргачлалын дагуу хийж байна.
- 2 Үнэлгээнд цахим технологи хэрэглэж байгаа нь байгууллага, орон нутаг, үндэсний түвшинд эерэгээр нөлөөлж байна.
- 3 Үнэлгээний үр дүн нээлттэй болсноор бүх түвшинд хэрэглэж байна.
- 4 Олон улсын ПИСА үнэлгээнд оролцсон.


Сургуулийн байршлаар үзүүлсэн үр дүн



Сургалтын байгууллага болон шалгалтын төрлөөр бүлэглэсэн үр дүн



Аймаг, дүүргийн гүйцэтгэлийг улсын дундажтай харьцуулсан дүн



ЦААШИД ЗАЙЛШГҮЙ САЙЖРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 1 Цахим үнэлгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, суралцагчдын бие даан суралцах чадварыг дэмжихтэй уялдуулах
- 2 Цахим үнэлгээ хийх орчин нөхцөлийг бүрдүүлэх
- 3 Боловсролын их өгөгдөлтэй болж байгаатай уялдуулан хувь хүний үнэлгээний нууцлалыг сайжруулах
- 4 Ялгаатай хэрэгцээг харгалзан даалгаврын сан бүрдүүлэх
- 5 Сургалтын үр дүнг үнэлэх даалгаврын тавилыг өөрчлөх
- 6 СӨБ, МБ зэрэг түвшний онцлогийг харгалзан гүйцэтгэлийн үнэлгээ хийхдээ хувилбарт сургалт болон бусад нөхцөлийг тооцож уян хатан байх
- 7 Бүх түвшний сургалтын хөтөлбөр болон үнэлгээний агуулгын залгамж холбоо, нийцийг сайжруулах
- 8 Үнэлгээний зарим үүргийг чадавх бүхий ТББ, хувийн хэвшилд үе шаттай шилжүүлэх
- 9 Үнэлгээ, чанарын баталгаажуулалтыг үндэсний мэргэшлийн хүрээтэй уялдуулах;

Боловсролын салбарын хүний нөөц нь бусад нийгмийн салбараас хамгийн өргөн хүрээг хамардаг бөгөөд төрийн албан хаагчдын 21.2 хувийг эзэлж байна.

Боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтан

				ТӨР			ХУВЬ		
СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	Багш	8472	1261	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА	Багш	33461	4182		
	Удирдах ажилтан	989	371		Удирдах ажилтан	2195	470		
	Мэргэжилтэн судлаач	1510	138		Мэргэжилтэн судлаач	1765	255		
	Боловсролын туслах ажилтан	7455	1220		Боловсролын туслах ажилтан	1271	355		
	Бусад ажилтан	11737	846		Бусад ажилтан	13974	1212		
33999				59140					

				ТӨР			ХУВЬ		
МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА	Багш	1914	437	ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА	Багш	3322	1647		
	Удирдах ажилтан	49	32		Удирдах ажилтан	351	324		
	Мэргэжилтэн судлаач	48	28		Мэргэжилтэн судлаач	682	234		
	Боловсролын туслах ажилтан	85	12		Боловсролын туслах ажилтан	719	488		
	Бусад ажилтан	1338	225		Бусад ажилтан	2238	1316		
4168				11664					

БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧИД



Удирдах ажилтан



Багш



Боловсролын туслах ажилтан



Мэргэжилтэн, судлаач



Бусад ажилтан

Боловсролын үндэсний байгууллага	63			411	28
Орон нутгийн боловсролын газар, хэлтэс	31			409	149
Насан туршийн суралцахуйн төв	53	460	1	17	93



**БОЛОВСРОЛЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ БУЙ ХАМГИЙН
ЧУХАЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 1 Боловсролын салбарын хүний нөөцийн нэгдсэн, суурь мэдээлэлд үндэслэж, хүний нөөцийн бүрдүүлэлт, хөгжүүлэлтийн нэгдсэн бодлого, төлөвлөгөөтэй болох
- 2 Ерөнхий боловсролын болон насан туршийн суралцахуйн багш бэлтгэх тогтолцоо, багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэх
- 3 Багш бэлтгэдэг их, дээд сургуулийн багш нарыг чадавхжуулах
- 4 Мэргэжлийн болон техникийн, их, дээд боловсролын сургалтын байгууллагын багш бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх
- 5 Боловсролын салбарын хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх болон нийгмийн асуудлыг шийдэхэд хиймэл оюун ухаан, их өгөгдлийг ашиглах, бусад салбартай хамтран ажиллах, түншлэх арга замыг хөгжүүлэх
- 6 Аймаг, нийслэл зэрэг орон нутгийн түвшинд ажиллаж буй боловсролын байгууллагын ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжих тогтолцоог бүрдүүлэх
- 7 Дэлхийн шилдэг сургуулиудад орон нутгийн төлөөллийг жигд харгалзан, шалгуур хангасан суралцагчдад зээл, тэтгэлэг олгож боловсон хүчин бэлтгэх болсон.
- 8 Сэтгэл зүйч, хоол зүйч, нийгмийн ажилтан, эмч, номын санч зэрэг багш бус мэргэжлийн боловсролын ажилтнуудыг хөгжүүлэх, мэргэжил дээшлүүлэх бодлого, зохицуулалтыг тодорхой болгох

СУРГАЛТЫН БИЕТ ОРЧИН

Бүх түвшний сургалтын байгууллага, суралцагч


	СУРАЛЦАГЧ (мянга)	СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА	үүнээс НИЙСЛЭЛД	үүнээс ОРОН НУТАГТ
ЦЭЦЭРЛЭГ	274.2	1410	46.7%	53.3%
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ	771.7	871	34.6%	65.4%
МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА	38.3	76	49.4%	50.6%
ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ	145.3	64	92.2%	7.8%

Цэцэрлэг, сургуулийн бүлэг
дүүргэлт (улсын дунджаар)



НИЙСЛЭЛ	ОРОН НУТАГ
30.3	29.7
33.4	27.6

Өөрийн эзэмшлийн, стандартад нийцсэн барилгын эзлэх хувь




СУРАХ БИЧИГ, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Ерөнхий боловсролын сургуулийн I-XII ангийн сурах бичиг

БАГА АНГИД	ДУНД АНГИД	АХЛАХ АНГИД	ХАНГАЛТ		
49	71	42	БАГА АНГИД	ДУНД АНГИД	АХЛАХ АНГИД
Үүнээс: Казак хэлээр 5 , Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн 11	Үүнээс: Казак хэлээр 4 ,		90%	80%	88.3%


Хэвлэмэл сурах бичиг



Бага ангийн
33 сурах бичиг




Интерактив сурах бичиг




Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрны 86.9 хувь нь интернетэд, 98.5 хувь нь боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон.

ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

Долоо хоногийн бүх өдөр халуун хоолоор үйлчилдэг сургуулийн эзлэх хувь



Ерөнхий боловсролын сургуулийн гал тогоо



Төрийн өмчийн бүх ерөнхий боловсролын сургууль нь зориулалтын гал тогоотой болсон.



СУРГАЛТЫН ОРЧНЫ ХҮРТЭЭМЖ, ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ЗАЙЛШГҮЙ ШИНЭЭР ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 1 Бүх түвшний болон насан туршийн боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хэрэглэгдэхүүн, материалын үйлдвэрлэлийг дэмжих, сургалтад хэрэглэх нөхцөл бүрдүүлэх
- 2 Суралцахуйг дэмжих цахим сургалтын орчны стандартыг боловсруулж, мөрдөх
- 3 Суралцагчийг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй суралцах сургалтын орчныг бүрдүүлэх, хэрэглэгдэхүүн, материалаар хангах
- 4 Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад зориулсан “сургалтын тохируулгат орчин”-ыг бүрдүүлэх
- 5 Цэцэрлэг, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд хүргэх
- 6 Дунд, ахлах ангийн суралцагчдыг “Үдийн хоол” хөтөлбөрт хамруулах
- 7 Төрөлжсөн ахлах сургуулийг хөгжүүлэх
- 8 Номын сангийн фондыг өргөжүүлэх, үйлчлүүлэгчийн тоог нэмэгдүүлэх
- 9 Мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагад сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн дундын сүлжээ лабораторийг байгуулах

**БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ
(ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ)**




**ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ХҮНИЙ БОЛОН МАТЕРИАЛЛАГ НӨӨЦИЙН
БҮРДҮҮЛЭЛТ, ХӨГЖҮҮЛЭЛТ**

Боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх, сургууль, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн харилцаа, холбоог бэхжүүлэх, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломжийг 2021 оноос эхлэн эрчимтэй бүрдүүлж эхлээд байна. Тухайлбал, боловсролын салбарт үдийн хоолны цахим хяналтын системийг анх удаа нэвтрүүлэв. Сургууль, цэцэрлэгийн тогооч тухайн өдөр хийсэн хоолныхоо зургийг хяналтын системд байршуулснаар сургуулийн эмч, хоол зүйч, БШУЯ, аймаг, дүүргийн боловсролын газраас ч хянах боломж бүрдсэн.



“Оюутан цэрэг” хөтөлбөрт хамрагдах бүртгэлийг 2022 онд анх удаа e-mongolia.mn-ээр зохион байгуулж, нийт 1472 оюутан бүртгүүлэв.



Medle.mn платформын ээлжит хичээлийн цахим контентийн санд нь 2023 онд нийтдээ 16500 хичээлийг байршуулав.



Гэрэгэ Эдтек ХХК “Сурах бичгийн цахим бүртгэл, хяналтын систем”-ийг 840 гаруй сургуульд нэвтрүүлэв.




Монгол улс боловсролын салбарын цахим шилжилтээрээ амжилттай тэргүүлэгч 5 орны нэг болов.




“Medle” цахим сургуульд 21 аймаг, 9 дүүрэг, БНСУ дахь Монгол сургуулийн Х ангийн нийт 9622 суралцагч 16 судлагдахуунаар судалцаж байна.

**БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН НӨӨЦИЙН
БҮРДҮҮЛЭЛТ, ХӨГЖҮҮЛЭЛТ**

Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээ, түүний бүрэлдэхүүн




Ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээ, түүний бүрэлдэхүүн



Дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээ, түүний бүрэлдэхүүн


Дотуур байрны үйл ажиллагааны зардал



Дотуур байрны багшийн цалингийн сан, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл

Дотуур байрны захиргаа, аж ахуйн ажилтны орон тооны жишиг нормативаар тооцсон үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл

**БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН УДИРДАХ АЖИЛТНЫ НӨӨЦИЙН БҮРДҮҮЛЭЛТ,
ХӨГЖҮҮЛЭЛТ**



Боловсролын бодлого, хэрэгжилт



Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичиг Хэрэглэгдэхүүн



Боловсролын сургалтын байгууллагын сургалтын үйл ажиллагаа



Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа




Суралцагчийн тасралтгүй хөгжил



Цахим сургалт, сургалтын цахим систем

Удирдах ажилтны чиг үүрэг.





Удирдах ажилтны нөөцийн хүрээнд

- 1 Боловсрол, сургалтын байгууллагын удирдах ажилтныг бэлтгэх, бүрдүүлэх, хөгжүүлэх, бэхжүүлэх (нээлттэй, хөрвөх болон зөөлөн үр чадвартай)
- 2 Боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтанг бэлтгэдэг баклаварын хөтөлбөр хэрэгжүүлэх. Ингэхдээ боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтны хөтөлбөрийг багш бэлтгэдэг их, дээд сургууль дээр бус удирдлага менежментийн хөтөлбөр хэрэгжүүлдэг их, дээд сургуульд хэрэгжүүлэх
- 3 Удирдах ажилтныг сонгон шалгаруулахдаа мерит зарчимд тулгуурлах, хамт олны дэмжлэгийг харгалзан үзэх, улс төрөөс ангид байх шаардлага, шалгуурыг бодитойгоор хэрэгжүүлэх

Санхүүгийн нөөцийн хүрээнд

- 1 Сургалтын байгууллагад гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн шинэ тогтолцоог бүрдүүлж, бэхжүүлэх сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх
- 2 Төсвийн шинэчлэлийн хүрээнд сургуулийн санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин урамшууллын тогтолцоог бүрдүүлэх, бэхжүүлэх.

Цахим үйлчилгээг дэмжих болон материаллаг нөөцийн хүрээнд

- 1 Байнгын, саадгүй ажиллагааг хангах хүний нөөц болон төсвийн төлөвлөлтийг тогтмол хийх
- 2 Үндэсний мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх, бэхжүүлэх, аюулгүй байдлыг хангах, дата өгөгдлөө ашигладаг байх
- 3 Интернетийн хурд, тоног төхөөрөмжийн дутагдал, дэд бүтцийн хязгаарлагдмал байдлыг шинэчлэх
- 4 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн сайн жишээ